


ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК



2023 | ЖИЛИЙН
ТАЙЛАН

АГУУЛГА

АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, ЭРХЭМЛЭХ ҮНЭТ ЗҮЙЛС, НЭГДСЭН СТРАТЕГИ ҮР ДҮН	3
УДИРТГАЛ	4
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	6
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ	9
ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	
ЗОРИЛТОТ ТҮВШИН	10
ЗАХИРГАА УДИРДЛАГА, ХҮНИЙ НӨӨЦ	12
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ	14
МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ	16
ШУУРХАЙ ЗОХИЦУУЛАЛТ	18
РЕЛЕ ХАМГААЛАЛТ, АВТОМАТИК, ХЭМЖИЛТ ТУРШИЛТ	27
ТЕХНИКИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ	30
ЗАСВАР ЗОХИЦУУЛАЛТ	33
ХАМТЫН АЖИЛЛАГАА, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР	36
2023 ОНЫ ШИЛДЭГ 10 АЖИЛ	38
2023 ОНЫ ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ	45
2024 ОНЫ ЗОРИЛТ	46



АЛСЫН ХАРАА

Цахилгаан дамжуулах
үндэсний "УХААЛАГ"
сүлжээ болох.



ЭРХЭМ ЗОРИЛГО

Аюулгүй ажиллагааг эрхэмлэж,
байгаль орчинд ээлтэй,
дэвшилтэт технологи ашиглан
цахилгаан эрчим хүчийг үр
ашигтай дамжуулна.



НЭГДСЭН СТРАТЕГИ ҮР ДҮН

Чадварлаг хүний нөөц,
дэвшилтэт техник технологи
бүхий үндэсний дамжуулах
сүлжээ болно



ЭРХЭМЛЭХ ҮНЭТ ЗҮЙЛС

Мэдлэг, ур чадвар, хүний хөгжил
Аюулгүй байдал
Багаар ажиллах
Шинэ санаа, бүтээлч сэтгэлгээ
Шударга, хариуцлагатай байдал
Компанийн нэр төр



Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн хамт олон улс орны өсөн нэмэгдэж байгаа цахилгаан эрчим хүчний эрэлт хэрэгцээг хязгаартай нөөц бололцоогоор зохицуулан эрчим хүчийг найдвартай дамжуулах үүргээ биелүүлэн ажиллаж байна.

Монгол Улс, БНХАУ-ын эрчим хүчний салбарын хамтын ажиллагаа, түншлэлийн харилцааг бататган компани Өвөр Монголын “Эрчим Хүчний Олон Улсын Хамтын Ажиллагааны Компани”-тай 2012 оноос хэлэлцээ хийж, хамтын ажиллагааг эхлүүлэн 2017 онд Монгол Улсын Оюу толгой төсөлд зориулж ӨМЭХОУХАК-тай “Цахилгаан эрчим хүч худалдан авах, худалдах тухай гэрээ”-г 6 жилийн хугацаатай байгуулсан. Оюу толгой уурхайн үйл ажиллагаа эрчимжиж, цахилгааны хэрэглээ өсөн нэмэгдсэнтэй холбогдуулан 2023 оны 05 дугаар сард тус гэрээний “Нэмэлт гэрээ”-г байгуулснаар гэрээний хүчин төгөлдөр үйлчлэх хугацааг сунгаж, уурхайн эрчим хүчний хангамжийг найдваржуулсан.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд эрчим хүчний салбарт хийгдэх томоохон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллалаа. Тухайлбал, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн “Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуур”-ын төсөлд хамтран ажиллаж, ондоо багтаан ашиглалтад хүлээж авсан. Дэлхийд томд тооцогдохуйц 80 МВт суурилагдсан хүчин чадалтай, 200 МВт цагийн багтаамж бүхий Литиум-Ион төрлийн батарей ашигласан хуримтлуурын байгууламжийг суурилуулж, 220/110/35 кВ-ын “Сонгино” дэд станцад холбосноор Монгол улсын Төвийн бүсийн эрчим хүчний системийн тогтвортой ажиллагаа дээшилсэн. Үйлчлэх хүрээгээ тэлэх зорилтоор Бөөрөлжүүт-Багануур чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын нэгдүгээр багцын барилга угсралтын ажлыг гүйцэтгэснээс гадна 220/110/35 кВ-ын “Багануур” дэд станцын 220 кВ-ын ил хуваарилах байгууламжийн өргөтгөлийн ажлыг дуусгаад байна. Чойр-Сайншандын төслийг хэрэгжүүлэх нэгжийг байгуулан зөвлөх үйлчилгээний тендерийг зарлаж, 220 кВ-ын Мандалговь-Арвайхээр, 220 кВ-ын Багануур-Чойрын ЦДАШ, дэд станцын ТЭЗҮ-г боловсруулж, Дэлхийн банкны хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. Ухаалаг сүлжээ болох зорилтын хүрээнд Power BI систем ашиглан Dashboard хөгжүүлж, улмаар өөрийн SCADA-тай болох цахим, дижитал шилжилтийн эхлэлийг тавьсан. Мөн 110 кВ-ын Ерөө-Бугант ЦДАШ-ын тасралтын судалгаа, тооцооллыг үндэслэн ОХУ-ын “Полимер аппарат” компанийн үйлдвэрлэсэн хэт хүчдэл хязгаарлагчийг нийт 35 тулгуурт суурилуулан 220/110/35 кВ-ын “Чойр” дэд станцын автотрансформаторын бүрэн задаргаат их засварын ажлыг хийж, 110/10 кВ-ын “Буюнт-Ухаа” дэд станцын Т-2 трансформаторын гэмтлийг засварласан. Компани 220/110/35 кВ-ын “Эрдэнэт”

дэд станцад 63 МВа-ийн Т-1, Т-2 трансформатор, “Баянхонгор” дэд станцад 16 МВа-ийн Т-1 трансформатор, “Мөрөн” дэд станцад 6,3 МВа-ийн Т-3 трансформатор, “Хархорин” дэд станцад 15 МВАр-ын, “Баянхонгор” дэд станцад 5 МВАр-ын СВГ суурилуулж, ажилд залгах зэрэг томоохон ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах үүднээс санхүүгийн нөөц бололцоогоо ашиглан 2023 оны 06 дугаар сараас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур цалинжиж байгаа ажилтнуудын цалинг нэмэгдүүлж, амьжиргааны өртгийн өсөлттэй уялдуулан ажилтнуудын үндсэн цалинг 2023 оны 11 дүгээр сараас 20% хүртэл хувиар нэмэгдүүлэх арга хэмжээг авч ажилласан.

Компани өмнөх онтой харьцуулахад 2023 онд Монгол Улсын төсөвт 11.7 тэрбум төгрөгөөр илүү буюу 89,281.4 сая төгрөг төвлөрүүлэн 506,814.2 сая төгрөгийн орлоготой ажиллахаас 541,910.8 сая төгрөгийг орлогод авч, төлөвлөгөөг 106.9 % биелүүлсэн.

Цахилгаан эрчим хүчийг тасралтгүй найдвартай дамжуулах эрхэм үүргээ нэр төртэй биелүүлж, жараад жилийн түүхийг өртөөлсөн дамжуулах сүлжээнийхэн улс орны болон эрчим хүчний салбарын хөгжлийн төлөө чин халуун сэтгэлээр хөдөлмөрлөж, урагшлан тэмүүлж, арвин их туршлага, нэр хүндээ өндөрт өргөхийн хүсэл тэмүүллээр дүүрэн ажиллаж байна.

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Б.ДАШДАВАА



ХАНГАЙН БҮСИЙН САЛБАР

Орхон, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Архангай,
Өвөрхангай, Баянхонгор, Булган, Завхан, Өмнөговь Дундговь
Говь-Алтай аймгууд



ЦДАШ



ДС

12

1522,75 км

625,6 МВА

ТӨВИЙН БҮСИЙН САЛБАР

Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгууд



ЦДАШ




ДС

18

909,20 км

452,8 МВА



ГОВИЙН БҮСИЙН САЛБАР

Дундговь, Дорноговь, Өмнөговь, Төв аймгууд



ЦДАШ



ДС

5

844,8 км

835 МВА

БНХАУ

УЛААНБААТАР САЛБАР

Баянзүрх, Хан-Уул, Чингэлтэй, Сүхбаатар, Сонгинохайрхан, Налайх, Багахангай дүүргүүд, Төв аймгийн Баянчандмань сум



ЗҮҮН-ӨМНӨД БҮСИЙН САЛБАР

Багануур дүүрэг, Хэнтий, Говьсүмбэр, Дорноговь, Сүхбаатар, Төв аймгууд



ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ

Төрийн Өмчит Хувьцаат Компани

Байгуулагдсан он: 1967
Салбар: 5

Ажилтны тоо: 1293
ЦДАШ-ын нийт трассын урт: 5214,8 км
220 кВ-ын ЦДАШ: 2024,82 км
110 кВ-ын ЦДАШ: 3203,9 км
35 кВ-ын ЦДАШ: 23,7 км

Нийт дэд станцын тоо: 82
220 кВ-ын дэд станц: 11
110 кВ-ын дэд станц: 70
35 кВ-ын ИХБ: 1

Хамрах хүрээ:

Нутаг дэвсгэрийн 66% буюу 1.033.000 км²
Хүн амын 72% буюу 2.301.854 хүн
Зүүн захын цэг:
110/10 кВ-ын Өндөрхаан дэд станц 603 км
Баруун захын цэг:
110/10 кВ-ын Тэлмэн дэд станц 691 км
Хойд цэг:
ОХУ-МУ-ын хил 220 кВ-ын 257, 258-р
ЦДАШ 271 км урт
Урд цэг:
БНХАУ-МУ-ын хил 220 кВ-ын Оюутолгой
ЦДАШ 721 км урт



ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Ардын хувьсгалт намын 15 дугаар их хурлаас батлагдсан намын 4 дэх программыг хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд Дархан-Улаанбаатарын чиглэлд 110 киловольтын цахилгаан дамжуулах агаарын шугамыг барьснаар 1967 оны 07 дугаар сарын 05-ны өдөр Төвийн бүсийн эрчим хүчний систем болох Цахилгаан дамжуулах сүлжээ үүссэн түүхтэй. 1974 онд Орхон-Эрдэнэтийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам баригдаж, Эрдэнэт хотод 110/6 кВ-ын 2х6300 кВА түр дэд станц ашиглалтанд орсоноор Хангайн бүсийн салбар үүсэх эхлэл тавигдсан. 1978 онд Төв аймгийн Баяндэлгэр сумын Нүүрэнтийн хөндийд Багануурын нүүрсний уурхайг цахилгаан эрчим хүчээр хангахаар 110/6 кВ-ын түр дэд станцыг ашиглалтанд оруулсан нь Зүүн-Өмнөд бүсийн салбарын эхлэл болсон. Эрчим хүчний салбарыг зах зээлийн тогтолцоонд шилжүүлэх зорилгоор Монгол улсын их хурлаас Эрчим хүчний тухай хуулийг шинэчлэн баталснаар 110 болон 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын өмчлөл, ашиглалт засварын үйл ажиллагааг хариуцсан Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ төрийн өмчит хувьцаат компани 2001 оны 08 дугаар сард албан ёсоор байгуулагдсан.

Компани нь үйл ажиллагаагаа тэлж, 2012 онд нийслэл хотод Улаанбаатар салбарыг, 2013 онд өмнийн говийн уул уурхайг түшиглэсэн шинэ сууршлын бүсүүдийг эрчим хүчээр хангах Говийн бүсийн салбарыг байгуулснаар өдгөө 5 салбартайгаар үйл ажиллагаа явуулж, Монгол Улсын нутаг дэвсгэрийн 66 хувь /1.033.00 км²/, хүн амын 72 хувийг хамарч, 220, 110, 35 кВ-ын нийт 82 дэд станц, 80 МВт-ын батарейн хуримтлуурын 1 станц, 220 кВ-ын 2032.82 км, 110 кВ-ын 3227.10 км, 35 кВ-ын 23.7 км цахилгаан дамжуулах агаарын шугамаар Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон, Булган, Архангай, Өвөрхангай, Сэлэнгэ, Хөвсгөл, Баянхонгор, Төв, Дорноговь, Дундговь, Хэнтий, Говьсүмбэр, Өмнөговь, Сүхбаатар, Завхан зэрэг аймгуудын 300 гаруй сум суурин газрыг цахилгаан эрчим хүчээр хангаж, 110, 220, кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын ашиглалт, засвар үйлчилгээг хариуцан ажиллаж байна.

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” төрийн өмчит хувьцаат компани нь үндэсний аюулгүй байдлын зөвлөмжийн дагуу стратегийн ач холбогдол бүхий 100 хувь төрийн өмчит хаалттай хувьцаат компани бөгөөд нийт хувьцааны 66 хувийг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 34 хувийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн Засгийн газраас эрх олгосон төрийн байгууллага эзэмшдэг.

Тус компани нь төв удирдлага дахь 10 хэлтэс, төсөл хэрэгжүүлэх нэгж болон Улаанбаатар, Төвийн бүсийн, Хангайн бүсийн, Зүүн-Өмнөд бүсийн, Говийн бүсийн гэсэн 5 салбарын бүтэц зохион байгуулалттайгаар дараах тусгай зөвшөөрлийн хүрээнд үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Цахилгаан дамжуулах
2. 220 кВ болон түүнээс дээш хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам, дэд станцын, засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх
3. 0.4-110 кВ болон түүнээс дээш цахилгаан дамжуулах шугам, дэд станцын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах
4. Цахилгаан импортлох (БНХАУ-аас)
5. Мэргэжлийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх
6. Харилцаа холбооны үйлчилгээний сүлжээ байгуулах, түүний ашиглалт, үйлчилгээ эрхлэх

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь “Компанийн тухай хууль”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”, “Төрийн хэмнэлтийн тухай”, “Эрчим хүчний тухай хууль”, бусад хууль тогтоомж, удирдах байгууллагын шийдвэрийг мөрдлөг болгон компанийн үйл ажиллагааг чиглүүлэх, техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг ханган биелүүлэх, санхүү, эдийн засгийн үйл ажиллагааг дээшлүүлэх, техник, технологийн найдвартай ажиллагааг хангах, төрийн өмчийн ашиглалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулахад анхаарч, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажилласан.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 9, 10 дугаар тогтоолоор томилогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн:

Төрийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүд:

1. ТҮЗ-н дарга З.Мөнх-Оргил (ЭХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга)
2. Г.Гэрэлт-Од (ЭХЯ-ны Салбарын хяналтын газрын мэргэжилтэн)
3. М.Гансүх (ЭХЯ-ны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Цахилгааны хэлтсийн ахлах шинжээч)
4. Л.Отгонжаргал (ЭХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын шинжээч)
5. Э.Ганчимэг (ТӨБЗГ-ын ТӨХШХ-ийн ахлах мэргэжилтэн)
6. Г.Дэлгэрмаа (ТӨБЗГ-ын ТӨҮЗХ-ийн мэргэжилтэн)

Хараат бус гишүүд:

7. Д.Пүрэвбаяр (“Эрчим хүчний хөгжлийн төлөө Монголын нийгэмлэг” төрийн бус байгууллагын захирал)
8. Ж.Арслан (ШУТИС-ийн Судалгаа хөгжүүлэлтийн албаны дарга)
9. З.Ширзана (“Эрчис ойл” ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирал)

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга:

10. П.Аюушбилэг (ЦДҮС ТӨХК-ийн Захиргаа удирдлагын хэлтсийн дарга)

Төлөөлөн удирдах зөвлөл нь 2023 онд Эрчим хүчний сайдаас өгсөн удирдамж чиглэлийн дагуу хуралдаж, удирдамжийн хэрэгжилт 100 хувийн биелэлттэй байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын болон Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол шийдвэрээр 2023 онд гүйцэтгэх захирал болон компанийн эрх бүхий албан тушаалтанд 47 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилласнаар өгсөн үүрэг даалгавар бүрэн биелсэн.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинэчлэн томилсонтой холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодыг ТҮЗ-н 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 16 дугаар тогтоолоор шинэчлэн байгуулав.



ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН

хэмжих нэгж- мян.кВт.цаг

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны гүйцэтгэл	2023 оны		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөөтэй		Өмнөх оны мөн үетэй	
						Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Дамжуулах цахилгаан эрчим хүч	сая.кВт.ц	7,279.1	7,488.3	7,777.4	289.1	103.9	498.3	106.8
	Дамжуулалтын алдагдал	хувь	3.51	3.58	3.55	0.0	99.3	0.0	101.3
	биетээр	сая.кВт.ц	255.1	267.8	276.2	8.4	103.1	21.0	108.2
	Дамжуулсан цахилгаан эрчим хүч	сая.кВт.ц	7,024.0	7,220.5	7,501.2	280.8	103.9	477.2	106.8
2	Нийт орлого	сая.төг	483,368.7	506,814.2	541,910.8	35,096.6	106.9	58,542.1	112.1
	Үүнээс: Үндсэн үйл ажиллагааны орлого	сая.төг	55,424.9	66,862.4	65,735.8	-1,126.6	98.3	10,311.0	118.6
	Оюутолгой ХХК-тай ЦЭХ, худалдан авах, худалдах гэрээний дагуу тооцсон орлого	сая.төг	416,304.1	425,693.0	458,855.7	33,162.7	107.8	42,551.7	110.2
	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	сая.төг	11,639.8	14,258.7	17,319.2	3,060.5	121.5	5,679.5	148.8
3	Нийт зардал	сая.төг	488,155.0	515,240.6	548,566.4	33,325.8	106.5	60,411.5	112.4
	Үүнээс: Үндсэн үйл ажиллагааны зардал	сая.төг	67,322.3	86,209.2	85,764.5	-444.7	99.5	18,442.2	127.4
	Оюутолгой ХХК-тай ЦЭХ, худалдан авах, худалдах гэрээний дагуу тооцсон зардал	сая.төг	416,304.1	425,693.0	458,855.7	33,162.7	107.8	42,551.7	110.2
	Үндсэн бус үйл ажиллагааны зардал	сая.төг	4,528.6	3,338.4	3,946.2	607.8	118.2	-582.5	87.1
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/	сая.төг	-4,786.3	-8,426.5	-6,655.6	1,770.9	79.0	-1,869.3	139.1
	Орлогын татварын зардал	сая.төг	0.2	0.0	3.9	3.9	0.0	3.8	2,389.4
5	Цэвэр ашиг алдагдал	сая.төг	-4,786.4	-8,426.5	-6,659.5	1,767.0	79.0	-1,873.1	139.1
6	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ноогдох зардал	төг	0.99	0.98	0.99	0.0	100.4	0.0	99.8
7	Нийт авлага	сая.төг	3,695.8	3,790.5	2,773.9	-1,016.6	73.2	-922.0	75.1
	Үүнээс: ЦЭХ	сая.төг	2,754.8	2,798.4	1,286.9	-1,511.5	46.0	-1,467.9	46.7
	Бусад	сая.төг	941.0	992.1	1,486.9	494.8	149.9	545.9	158.0
8	Нийт өр төлбөр	сая.төг	282,389.9	313,389.4	382,394.6	69,005.1	122.0	100,004.6	135.4
	Үүнээс: Богино хугацаат өглөг	сая.төг	983.5	1,699.7	1,476.7	-223.1	86.9	493.2	150.1
	Урт хугацаат өглөг	сая.төг	281,406.5	311,689.7	380,917.9	69,228.2	122.2	99,511.5	135.4
9	Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт	сая.төг	10,127.5	13,947.4	9,944.7	-4,002.7	71.3	-182.8	98.2
10	Нийт ажилтны тоо	хүн	1,280	1,293	1,286	-7.0	99.5	6.0	100.5
11	Цалингийн сан	сая.төг	31,487.1	39,958.3	40,991.9	1,033.6	102.6	9,504.8	130.2

Компанийн хэмжээнд 2023 онд 7488.2 сая.кВт.цаг цахилгаан эрчим хүч /ЦЭХ/ хүлээн авах төлөвлөгөөтэй байснаас гүйцэтгэлээр 7777.4 сая.кВт.цаг ЦЭХ хүлээн авч, биелэлт 103.8%-тай ба 7220.4 сая.кВт.цаг ЦЭХ дамжуулах төлөвлөгөөтэй байснаас 7501.2 сая.кВт.цаг ЦЭХ дамжуулж төлөвлөгөөний биелэлт 103.9%-ийн гүйцэтгэлтэй гарсан. Дамжуулалт өссөн нь:

1. 2023 оны хувьд жилийн нийт таван сард нь ЦЭХ-ний хөнгөлөлттэй байсан. Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор нийслэлийн болон аймгийн төв, арван мянгаас дээш хүн амтай сум, суурин газрын гэр хорооллын хоёр тарифт тоолууртай өрхийн орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны тариф болон сэргээгдэх эрчим хүчийг дэмжих тарифт хөнгөлөлт үзүүлэх тухай ЭХЗХ-ны 562-р тогтоолыг хэрэгжүүлэн ажилласантай холбоотой

2. 11, 12 дугаар сард цаг агаар хүйтэн байснаас шалтгаалан хэрэглээ өссөн.

3. Уул уурхайн хэрэглэгчдийн ЦЭХ-ий хэрэглээ өссөн байна. Цахилгаан эрчим хүчний дамжуулалтын дотоод хэрэглээ, техникийн алдагдалд 3.55 хувь буюу 276.2 сая кВт.цаг зарцуулж төлөвлөгөөнөөс 0.03 пунктээр буурсан байна.

Тайлант хугацаанд 541,910.8 сая төгрөгийн орлоготой, 548,566.4 сая төгрөгийн зардалтай, татварын дараахаар 6,659.5 сая төгрөгийн алдагдалтай, алдагдлын түвшинг 1,767.0 сая төгрөг буюу 21.0%-иар бууруулсан. Тайлант хугацаанд орлого төлөвлөснөөс 35,096.6 сая төгрөг буюу 6.9 хувиар өссөн. Үүнд Оюутолгой ХХК-тай байгуулсан “ЦЭХ худалдах, худалдан авах гэрээ”-ний дагуу 2023 онд БНХАУ-аас Оюутолгой ХХК-ийн 1,454.7 сая кВт.цаг импортолж, борлуулалтын орлого болон борлуулсан бүтээгдэхүүний өртгийн хэмжээ төлөвлөснөөс 33,162.7 сая төгрөгөөр өссөн, мөн компанид хэрэгжиж буй төслийн зээлд хамаарах гадаад валютын ханшийн бодит бус ашиг 2,373.8 сая төгрөг түс түс нөлөөлсөн. Компанийн 2023 оны зардлын төлөвлөгөө 33,325.8 сая төгрөгөөр өсөхөд Оюутолгой ХХК-тай байгуулсан “ЦЭХ худалдах, худалдан авах гэрээ” (дээрх тайлбартай адил)-ний дагуу бүртгэл хийсэн нь нөлөө үзүүлсэн.

Тайлант хугацаанд 1286 ажилтантай, цалингийн санд 40,991.9 сая төгрөгийг зарцуулжээ.

Их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажилд 9,944.7 сая төгрөг зарцуулж, тайлант хугацаанд улсын төсөвт 89,281.3 сая төгрөгийг төвлөрүүлэн, татвар төлөгчийн хувьд хүлээсэн үүргээ биелүүлж ажилласан.

2023 онд их засварын 293 ажлыг 3.6 тэрбум төгрөг, ТЗБАХ-ний 85 ажлыг 9.3 тэрбум төгрөг, ХО-н 43 ажлыг 1 тэрбум төгрөг буюу нийт 421 нэр төрлийн ажлыг 13.9 тэрбум төгрөгөөр хийхээр төлөвлөснөөс ИЗА-н 292, ТЗБАХ-ний 83, ХО-ын 43 буюу нийт 417 ажлыг 9.9 тэрбум төгрөгөөр 99 хувьтай гүйцэтгэсэн. Их засвараар төлөвлөсөн 208 дугаар АШ-ын тусгаарлагч солих ажлын материал тендер шалгаруулалтын улмаас хугацаандаа нийлүүлэгдээгүй, 2024 оны 3-р сард нийлүүлэгдэх тул энэ онд гүйцэтгэхээр төлөвлөж байна. ТЗБАХ-нд төлөвлөсөн Эрдэнэт дэд станцын 220 кВ-ын 10 ком хуурай салгуур солих, Арвайхээр 110 кВ ЦДАШ-н намагтай хэсэгт трасс өөрчлөх, Багануур дэд станцын 220 кВ ил хуваарилах байгууламжийн өргөтгөлийн ажлууд худалдан авах ажиллагааны явц, материал үйлдвэрлэх хугацаанаас шалтгаалж өвлийн их ачаалал эхэлсний дараа нийлүүлэгдсэн тул 2024 онд хийгдэж байна.

Оюу Толгой ХХК-тай байгуулсан “Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах тухай” гэрээний дагуу 458,855.7 сая төгрөгийн орлого, зардлыг тайлант хугацаанд бүртгэж, 67,735.8 сая төгрөгийн гааль, нэмэгдсэн өртгийн албан татварын тооцоог хийж ажилласан байна.

2021, 2022 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитаас өгсөн 6 зөвлөмж, 3 төлбөрийн акт, 5 албан шаардлага (2021 онд), 6 зөвлөмж, 1 төлбөрийн акт, 5 албан шаардлага (2022 онд)-ыг үндэслэн байгууллагын үндсэн үйл ажиллагаа болон санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг холбогдох газруудад хүргүүлэн ажилласан.

Компанийн нийт хөрөнгө 673,212.5 сая төгрөг болж, эргэлтийн хөрөнгө 14,987.6 сая төгрөг буюу 2.2%-ийг эргэлтийн бус хөрөнгө 658,225.0 сая төгрөг буюу 97.8%-ийг эзэлж байна.

Нийт өр төлбөр 382,394.6 сая төгрөг буюу 56.8%, эздийн өмч 290,817.9 сая төгрөг буюу 43.2%-ийг эзэлж байна.



ЗАХИРГАА УДИРДЛАГА, ХҮНИЙ НӨӨЦ

Компани 2023 онд дэвшүүлсэн 10 зорилт, 169 төлөвлөгөөт ажлыг 97.5 хувиар биелүүлж, удирдах дээд байгууллагын 216 үүрэг даалгавар (ЭХЯ-с 120, ТӨБЗГ-с 24, ХЭХ-с 9, ЭХЗХ-с 25, ТҮЗ-с 38) бүрэн хэрэгжсэн болно.

Оюутолгой төсөлд зориулж, цахилгаан эрчим хүч худалдан авах, худалдах “Нэмэлт гэрээ”-г 2023.05.12-ны өдөр ӨМЭХОУХАК-тай байгуулсан.

Эрчим хүчний салбарын 2023-2024 оны хамт /тариф/-ын хэлэлцээрийг үндэслэн компанийн Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд 2023-2024 онд хэрэгжүүлэх “Хамтын гэрээ”-г 2023.02.13-ны өдөр байгуулсан.

Хүний нөөцийн хомсдол, ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор ажилтнуудын цалин хөлсийг шат дараатай нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлсний үр дүнд ажилтны үндсэн цалин өмнөх оны мөн үетэй харьцуулахад дунджаар 68.5 хувь буюу 771,782 төгрөгөөр нэмэгдсэн. Компани тайлант жилд давхардсан тоогоор 3263 ажилтан, ахмад настанд 1,901.9 сая төгрөгийн хөнгөлөлт, 24 ажилтанд 612.6 сая төгрөгийн тэтгэмж, 55 ажилтан, ахмад настанд 513.0 сая төгрөгийн тусламж, 215 ажилтанд 89.1 сая төгрөгийн шагнал, урамшуулал олгосон.

Компанийн хүний нөөцийн тогтвортой хөгжлийг хангах, ажлын байрны үнэлэмж, бүтээмжийг дээшлүүлэхээр ажлын байранд тавигдах шаардлага, үр чадвар, үүрэг хариуцлагыг харгалзан компанийн түлхүүр 26 ажлын байрны жагсаалтыг баталсан.

Компанийн хэмжээнд 2001 оноос хойш мөрдөгдөж буй 74 дүрэм журмыг судалж, цахим аппликэйшнд байршуулж, Хөдөлмөрийн тухай шинэчилсэн найруулга болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн 15 журмыг шинээр болон шинэчлэн, нэмэлт өөрчлөлт оруулав.

Компанийн нийт ажилтны 52 хувийг инженер техникийн ажилтан, 48 хувийг бага тушаалын ажилтан эзэлж байна. Ажилтнуудын дундаж нас 39 бөгөөд эмэгтэй ажилтан нийт ажилтны 29.1 хувийг, хөгжлийн бэрхшээлтэй ажилтан 1.9 хувийг, өрх толгойлсон ажилтан 8.2 хувь байна. Ажилтнуудын 69.7 хувь нь дээд боловсрол эзэмшсэн бол 6.9 хувь нь магистрын зэрэгтэй байна. Компанийн хэмжээнд 48 зөвлөх, мэргэшсэн инженер ажилласан. Компанийн нийт орон тооны 52.0 хувийг шуурхай ажиллагааны 669 ээлжийн ажилтнууд эзэлж байна. Хүний нөөцийн бүрдүүлэлтийг орон тооны батлагдсан хязгаарт багтаан хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, 233 ажилтанг ажилд шинээр авч, 127 ажилтан албан тушаал дэвшин 166 ажилтан ажлаас чөлөөлөгдсөн байна.

Сургалтыг 53 нэр төрлөөр зохион байгуулж, давхардсан тоогоор 3093 ажилтныг хамруулсан. Тайлант жилд хамтын ажиллагаа болон эрчим хүчний салбарт хэрэгжүүлж буй зарим төслүүдийн үр дүнд гадаад сургалтад 48 ИТА хамрагдсанаар техник технологийн шинэ дэвшлийг судлах, суралцах, үр чадвараа дээшлүүлсэн. Японы ОУХАБ-аас /Олон улсын хамтын ажиллагааны байгууллага/-аас салбарт хэрэгжүүлж буй “Сэргээгдэх эрчим хүчний оролцоо ихтэй эрчим хүчний системийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх, чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд RTDS программ, Power Factor программын шинэ хувилбарыг ашиглах, сургагч багш бэлтгэх, РХА-н заавартай тавилын картыг газрын зураг дээр байршуулан боловсруулах, агаарын шугамын дамжуулагч утасны насжилтыг оношлох, төмөр тулгуурын цайрын бүрээсийн элэгдлийн түвшинг тодорхойлох, үзлэг шалгалт хийх гарын авлага боловсруулах зэрэг чиглэлээр мэдлэгээ дээшлүүлж, түршлага суралцсан. Компанийн хэмжээнд 2023 оны 11 дүгээр сард зохион байгуулсан “Инженер техникийн ажилтнуудын зөвлөгөөн-2023” арга хэмжээнд 95 инженер техникийн ажилтан оролцож, компанийн ахмадын хорооны дарга, Монгол Улсын зөвлөх инженер Л.Дарамбазар, “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын Ерөнхий инженер Ш.Энхбаатар, ШУТИС-ын барилга архитектурын сургуулийн профессор Я.Дүйнхэржав нар хүрэлцэн ирсэн. Тус зөвлөгөөнөөр компанийн шугам тоноглолын өнөөгийн нөхцөл байдал, тэдгээрийн ашиглалтад тулгамдаж буй асуудал, боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх, мэргэжлийн

ур чадварыг сайжруулах, шинэ дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, ухаалаг дамжуулах сүлжээ болох техникийн шийдэл, тооцоо судалгааг эрчимтэй хийж бие даасан "СКАДА" тоолуурын нэгдсэн системийг үүсгэх зэрэг 10 гаруй илтгэлийг сонсож, хэлэлцүүлэг өрнүүлсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу компанийн хэмжээнд нээлттэй болон харьцуулалтын тендер шалгаруулалтыг 100% цахимаар явуулж байна. Шилэн дансын тухай хуулийн дагуу худалдан авалт хийсэн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий бараа, ажил, үйлчилгээний мэдээллийг сар бүр цахим системд байршуулж олон нийтэд нээлтэй, хяналт тавих боломж бүрдүүлэн ажиллаж байна. Эрчим хүчний салбарын компаниудад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хагас жил тутамд хийх Эрчим хүчний яамны аудитын дүнгээр ЦДҮС ТӨХК нь 90% үнэлгээтэй дүгнэгдсэн.


Компанийн хамт олны дундаас "Аж үйлдвэрийн гавьяат ажилтан" тодорч, Засвар зохицуулалт, төслийн хэлтсийн ахлах бөгөөд шугамын засварын инженер С.Ариунбат "Эрчим хүчний салбарын шилдэг ажилтан"-аар шалгарч, Эрчим хүчний сайдын нэрэмжит шагналаар Шуурхай зохицуулалтын хэлтсийн дарга Ж.Чинзаяа, "Хөдөлмөрийн гавьяаны улаан түгийн одон"-оор 2, "Алтангадас одон"-оор 6, "Хөдөлмөрийн хүндэт медаль"-аар 7, "Эрчим хүчний тэргүүний ажилтан тэмдэг"-ээр 38, бусад салбарын "Тэргүүний ажилтан тэмдэг"-ээр 2, Эрчим хүчний яамны "Хүндэт жуух бичиг"-ээр 24 ажилтан тус тус шагнагдсан.

2023 онд гүйцэтгэх захирлын болон салбарын даргын тушаалаар нийт 39 ажилтанд хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ



“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-ийн 28 дугаар зүйлд заасан ажил олгогчийн эрх, үүргийн дагуу компанийн салбар, хэлтэс, нэгжүүдэд ААД, ТАД-ийн дагуу ээлжит давтан зааварчилгаа, аваар эсэргүүцэх дасгал, галын аюулаас урьдчилан сэргийлэх дасгалын сэдвийг баталгаажуулан мөрдүүлэн ажилласан. Анхан шатны 43009 үзлэгээр 1743 зөрчлийг илрүүлж, 1579 зөрчил бүрэн арилгасан. Хоёрдугаар шатны үзлэгийг давхардсан тоогоор 1354 удаа зохион байгуулж, 1681 зөрчлөөс 1288 зөрчлийг арилгах арга хэмжээ авсан. 218 удаагийн гуравдугаар шатны үзлэгээр 1383 зөрчлийг илрүүлж, үүнээс 644 зөрчлийг бүрэн арилгасан.



“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-ийн 26 дугаар зүйл заасны дагуу 2023 онд компанийн хэмжээнд ХАБЭА сайжруулах ажилд 897.7 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 833.6 сая төгрөг зарцуулсан.



Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хүрээнд хэвийн бус нөхцөлд (хортой, хүнд) ажилладаг давхардсан тоогоор 11471 ажилтанд 35.3 сая төгрөгийн хор саармагжуулах бүтээгдэхүүн олгосон. Компанийн хэмжээнд давхардсан тоогоор 2770 хүн ажлын аюулгүй байдлыг хариуцагчаар ажиллаж байна.



Тайлант хугацаанд 5 салбарын бүх ажлын байруудад эрсдэлийн үнэлгээ хийж, 373 эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч, 334 эрсдэлийг 2024 онд бууруулахаар төлөвлөөд байна. Компанийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах ажлын хүрээнд дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу РХАХТХ, МТХ, ЗЗТХ, ШЗХ, ТМХ, Улаанбаатар салбарын техникийн албадуудад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр хийсэн ажил, үүрэг даалгаврын хэрэгжилт, их засвар, ТЗБАХ-н ажил, анхан шатны баримт бичгийн хөтлөлт, сар тутмын дасгал, зааварчилгааны чанар, галын аюулгүй байдалд үзлэг шалгалтыг зохион байгуулж, илрүүлсэн зөрчлийг арилгуулах зөвлөмжийг хүргүүлж, хэрэгжилтийг 100 хувь хангуулсан.



МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

Компани “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ” үзүүлэх тусгай зөвшөөрлийг эзэмших болсноор хот суурин, барилга байгууламж хооронд харилцаа холбооны худаг, сувагчлал, шилэн болон зэс кабель шугам, агаарын шугам угсарч суурилуулах, барилгын дотор холбооны сувагчлал, сүлжээ байгуулах, тоног төхөөрөмжийн угсралт суурилуулалт, холболтын ажил үйлчилгээ, мөн цамхаг дээрх холбооны тоног төхөөрөмжийн угсралт суурилуулалтын, засвар үйлчилгээний ажлыг гүйцэтгэх боломжтой болж, дотооддоо 220/110кВ-ын агаарын шугамуудад шилэн кабель залгах, угсарч суурилуулах ажлыг амжилттай хэрэгжүүлээд байна.

Компанийн хэмжээнд Дата менежмент систем буюу мэдээ мэдээллийн нэгдсэн хяналтын самбарыг нэвтрүүлээ.




Компанийн өөрийн гэсэн СКАДА системтэй болох зорилтыг биелүүлэхийн тулд 2023 онд 12 дэд станцыг СКАДА системд оруулсан. Мөн ЦДҮС ТӨХК, ДҮТ ТӨХХК, УБЦТС ТӨХК-иудын СКАДА системийг интеграци хийх ажлыг гүйцэтгэв.



Нисгэгчгүй нисэх төхөөрөмжөөр шугамын үзлэг хийж, дүн шинжилгээ хийх, гэмтэл илрүүлэх зориулалттай хиймэл оюун ухаанд суурилан хөгжүүлсэн дүрс боловсруулалтын программыг, УБЦТС ТӨХК-тай хамтарч гамшгийн үед ашиглах тоон системийн өндөр давтамжийн орчин үеийн DMR системтэй радио холбоог нэвтрүүллээ. Өвлийн их ачааллын үед ачаалал хөнгөлөх автоматжуулалтын системд өндөр ачаалал бүхий дэд станцуудыг холбох, системийн аюулгүй найдвартай байдлыг дээшлүүлэх ажлын хүрээнд төв удирдлагын болон салбарын байр, Улаанбаатар салбарын дэд станц руу шилэн кабелийн холболт хийлээ. Компанийн хэмжээнд салбаруудын төхөөрөмжүүдийн IP хаягжилтыг “С” түвшнээс “А” түвшин рүү шилжүүлэн VPN сүлжээ болон нэгдсэн холбооны системийг дахин программчилснаар төхөөрөмжүүдийг нэг сүлжээнд олон тоогоор зохион байгуулах чадвар дээшилсэн.

Төв удирдлагын гадна интернэтийн урсгалыг UNIVISION, Монголын цахилгаан холбоотой хамтарч Монголдоо гигабит хурдаар холбогдох боломжтой болгож, сүлжээний хурдны түвшинг ахиулж хоёр урсгалыг SD-WAN технологиор гадна урсгал тасарсан үед автоматаар нөгөө урсгал руу хэрэглэгчдээ шилжүүлдэг болгож тохирууллаа.

Компанийн халдлага эсэргүүцэх системүүдэд өөрчлөлт шинэчлэлт хийж, салбар хоорондын сүлжээний өөрчлөлт тохируулгыг байнга хийж байна.





ШУУРХАЙ ЗОХИЦУУЛАЛТ

Цахилгаан эрчим хүчийг тасралтгүй, найдвартай дамжуулах, технологийн үйл ажиллагааг 24 цагийн турш уялдуулан зохицуулах, салбар, нэгж, хэсгүүдийг шуурхай ажиллагааны нэгдсэн удирдлагаар хангаж ажилласан.

80МВТ/200МВТ.ЦАГИЙН БАГТААМЖТАЙ СОНГИНО ДЭД СТАНЦАД ХОЛБОГДОХ ХУРИМТЛУУРЫН СИСТЕМИЙГ АЖИЛД ЗАЛГАСАН (BESS)

Монгол улсын анхны том чадлын батарей хуримтлуурын станцыг ашиглалтанд оруулахаар компанийн диспетчерүүд 2023.11.05-2023.12.08-ны өдрүүдэд шуурхай ажиллагааг хариуцан ажилласан. Энэ хугацаанд дөрвөн удаагийн техникийн комиссын шийдвэрийн дагуу Сонгино д/ст 110 кВ-н шинээр суурилуулсан БХС-н өргөтгөлийн СШ болон БХС-н 110 кВ-н бүх тоноглол, "Сонгино БХС-н үндсэн 2, дотоод хэрэгцээний 4, инверторын 32 трансформатор, 110/35/0.69/0.4 кВ-н бүх тоноглолыг хүчдэлд залгаж, ачаалал авахуулах нийт 2042 үйлдэл бүхий сэлгэн залгалтын программыг батлуулж, үйлдлийг гардан гүйцэтгэж, ажиллагаанд амжилттай залгасан. Батарей хуримтлуурыг ажиллагаанд залгаснаар өвлийн оргил ачааллын цагуудад импортын эрчим хүчний хэмжээг бууруулах боломжтой болсон.

ХАРХОРИН ДЭД СТАНЦАД 15 МВАР ЧАДАЛТАЙ СВГ ТӨХӨӨРӨМЖИЙГ АЖИЛЛАГААНД ОРУУЛСАН

Хангайн бүсийн салбарын алслагдсан дэд станцуудын хүчдэлийн түвшин оргил ачааллын цагуудад зөвшөөрөгдөх хэмжээнээс буурдаг тул Хархорин дэд станцын 110 кВ-н шинийн хүчдэлийг 115 кВ-р барьж, Баянхонгор, Арвайхээр, Баянтээг дэд станцуудад хүчдэлийг тохируулж ажиллах зорилгоор Монгол улсад анх удаа 291 үйлдэл бүхий сэлгэн залгалтаар 110 кВ-н хүчдэлийн түвшинг тохируулах 15 МВАр СВГ төхөөрөмжийг амжилттай залгалаа.

СЭЛГЭН ЗАЛГАЛТЫН ҮЛГЭРЧИЛСЭН ПРОГРАММЫГ ТОНОГЛОЛЫН НЭРШЛИЙН СТАНДАРТЫН ДАГУУ НЭГ ЗАГВАРТ ОРУУЛЖ, БОЛОВСРУУЛСАН

Салбарууд өөр өөрийн арга барилаар боловсруулсан сэлгэн залгалтын үлгэрчилсэн программ ашиглаж байгаа нь нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахад хүндрэл үүсгэж байгаа тул бүх төрлийн схемийн онцлогт тохируулан сэлгэн залгалтын үлгэрчилсэн загвар боловсруулж, батлуулах шатандаа ажиллаж байна.

ХАРЬЦААНЫ ЗААВАР БОЛОВСРУУЛАЛТ

Харьцааны зааврын гол зорилго нь эрчим хүчний системийн тогтворжилт, найдвартай ажиллагааг хангахад хоёр байгууллагын шуурхай ажиллагааны хүмүүсийн ажлын уялдаа, холбоог зохицуулах, тэдний эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлоход оршино. ДҮТ ТӨХХК, ЦДҮС ТӨХК болон бусад ТЗЭ нар нь 3 талын харьцааны зааврыг мөрдөж ажиллаж байсныг тус тусын харьцааны зааврыг боловсруулан батлуулж, мөрдөж ажиллах зохион байгуулалтын арга хэмжээ авсан. МУ-н ЭХС-д ЦЭХ нийлүүлж байгаа 7 нарны цахилгаан станц, 3 салхин цахилгаан станцын ТЗЭ нарын тус тусын харьцааны зааврыг шинэчлэн боловсруулж, ТЗЭ нарт хүргүүлсэн. Эх үүсвэр 6 дулааны цахилгаан станцуудын харьцааны зааврыг боловсруулж байна.


ШУУРХАЙ АЖИЛЛАГААНЫ АЖИЛТНУУДЫН ЗӨВӨЛГӨӨН

ЦДҮС ТӨХК-ийн шуурхай ажиллагааны удирдах ажилтнуудын зөвөлгөөнийг 2023 оны 04 дүгээр сард Өвөрхангай аймгийн Хархорин суманд амжилттай зохион байгуулж, төв удирдлага, 5 салбарын нийт 32 ИТА оролцов.



ДИСПЕТЧЕРИЙН ЗОХИЦУУЛАЛТ

2023 ОНД ШИНЭЭР ЗАЛГАГДСАН ШУГАМ ТОНОГЛОЛУУД



2023 онд 220/110/35 кВ-н Багануур дэд станцын 220 кВ-н өргөтгөл, 261, 262-р АШ, Сонгино БХС-н барилга угсралтын ажлыг гүйцэтгэж, Эрдэнэт дэд станцын шинэчлэлтэй холбоотойгоор Т-1, 2-г 63 МВА-р сольж, 35 кВ-н Зэс-А, Б гаргалгаагаар өргөтгөсөн. Хархорин дэд станц 15 МВар СВГ, Баянхонгор

дэд станцын 5 МВар СВГ-г тус тус хүчдэл тохируулахаар залгасан. Зүүнхараа, Баруунхараа, Тосгон дэд станцуудад ашиглалтын түвшин буурсан 110/35 кВ-н ЦШ-уудыг сольж, тоноглолын найдвартай ажиллагааг дээшлүүлсэн. Жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа ЦЭХ-ний хэрэглээтэй холбоотойгоор Эрдэнэт, Баянхонгор, Мөрөн дэд станцуудад хүчний трансформаторын чадлыг нэмэгдүүлсэн.



2023 ОНД ХИЙГДСЭН СЭЛГЭН ЗАЛГАЛТУУД

Компанийн хэмжээнд нийт 6318 сэлгэн залгалт хийснээс 220 кВ-т талд 570 удаа 110 кВ-т талд 2638-н удаа 35 кВ-т талд 770-н удаа 10 кВ-т талд 553-н удаа 6 кВ-т талд 397-н удаа хийсэн. Нийт сэлгэн залгалтын 597 нь нийлмэл сэлгэн залгалт, 4690 нь энгийн сэлгэн залгалт хийж, гүйцэтгэсэн байна.




Компанийн хэмжээнд нийт 6318 сэлгэн залгалт хийснээс 220 кВ-т талд 570 удаа 110 кВ-т талд 2638-н удаа 35 кВ-т талд 770-н удаа 10 кВ-т талд 553-н удаа 6 кВ-т талд 397-н удаа хийсэн. Нийт сэлгэн залгалтын 597 нь нийлмэл сэлгэн залгалт, 4690 нь энгийн сэлгэн залгалт хийж, гүйцэтгэсэн байна.

Онцгой горимын үед схемийн шийдэл гаргаж хэрэглэгчдийг тэжээсэн байдал

215, 216-р АШ-ын тулгуур №32 унасан үед хэрэглэгчдийг тэжээсэн онцгой үеийн схемийн шийдэл

Байгалийн давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан 2023.03.09-ний 20:31 цагт 215, 216-р АШ-ын тулгуур №32 төмөр дундын тулгуур унаж, тулгуур № 30, 31-н төмөр хийц хэсэг гулзайж гэмтсэн. Энэхүү саатлын /30 цаг тасарсан/ үед 529510,8 кВт/цаг ЦЭХ дутуу түгээх байсныг схемийн шийдэл боловсруулж, онцгой горимоор хэрэглэгчдийг тэжээх ажлыг амжилттай зохион байгуулж чадсан. Даланзадгад, Тавантолгой дэд станцуудыг УХЦС-аас, Оюутолгой дэд станцыг Оюутолгой уурхайгаас, Сайншанд дэд станцаас 35 кВ-н Зүүнбаян-Б АШ-р Зүүнбаян дэд станц, Зөрлөг-5, 6 дэд өртөөгөөр дайруулан Цагаансуварга дэд станцын 22 кВ-н I, II СШ-г тэжээж, Дорноговь аймгийн Хатанбулаг, Мандах сумын хэрэглэгчдийг хүчдэлтэй болгосон.




110/35/10 кВ Багахангай д/ст-н Т-1 гэмтэх үед хийсэн схемийн өөрчлөлт

Багахангай дэд станцын SFSZ9-16000 маркийн 16МВА чадалтай Т-1 хүчний трансформатор 2023.03.25-ны өдөр гэмтсэн тул 110 кВ-ын шинд 35 кВ-ын буултын утсыг холбох, 110 кВ-ын Багахангай ЦДАШ-ын тулгуур №1-ээс 35 кВ-ын Элстэй-А ЦДАШ-ын тулгуур №1 хооронд 3 фазын дамжуулагч утас татах техникийн арга хэмжээг авч, ЗӨБС-ын 110/6 кВ-ын Төв дэд станцын яч№30 “Төмөр замын 1” шугамаар дамжуулан 35/6 кВ-ын Өндөртолгой дэд станцад хүчдэл өгсөнөөр 45060 кВт/цаг ЦЭХ дутуу түгээх эрсдлийг бууруулж ажилласан.




107,108-р АШ-н тул№13,14, 109,110-р АШ-н тул№12,13, 205,206-р АШ-н тул№9-г зөөж шилжүүлэх, трасс өөрчлөх ажил





110 кВ Хархорин-А, Б ЦДАШ-ын тулгуур унах үед ажилласан байдал

2023 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 18 цаг 37 минутанд Булган-Хархорин чиглэлийн 110 кВ-ын 24 ширхэг тулгуур унасан. Тус гэмтлээс үүдэж Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Булган, Төв, Дундговь, Өмнөговь аймгуудын 82 сум цахилгаан эрчим хүчээр хязгаарлагдсан. Байгалийн давагдашгүй хүчин зүйл болох усархаг бороо орж, хүчтэй шуурсаны улмаас үүссэн гэмтлийг 5 салбарын 158 ажилтан, 40 орчим техник хэрэгсэлтэйгээр 2023.06.26-ны өдрөөс эхлэн 4 хоногийн турш 24 цагаар шуурхай ажиллан, бүрэн арилгаж 2023.06.29-ний өдрийн 20 цаг 24 минутад цахилгаан эрчим хүчинд холболоо.




2023 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 22:40 цагаас 23:10 цагийн хооронд Архангай аймгийн Хашаат сумын нутгаар хүчтэй аадар бороо орж, 27 м/сек хүчтэй шороон шуурга шуурсаны улмаас Хархорин дэд станцаас 40 км орчим зайд байрлах 110 кВ-ын Хархорин А, Хархорин Б цахилгаан дамжуулах агаарын шугамын 679-683 дугаар хүртэл тулгуур (ПБ110-8 маркийн 5 ширхэг төмөр бетон) хугарч, 7 аймаг, 57 сумдын 45320 хэрэглэгч, 5256 аж ахуйн нэгж цахилгаан эрчим хүчээр хязгаарлагдсан. 110 кВ-ын Хархорин А, Б ЦДАШ-н гэмтэл устгах, сэргээн засварлах ажлыг 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 06:37 цагаас 08 дугаар сарын 15-ны өдрийн 17:34 цагийн хооронд Улаанбаатар болон Хангайн бүсийн салбарын нийт 96 ажилтан, 24 техник хэрэгсэлтэйгээр 43 цагийн дотор амжилттай гүйцэтгэж, хязгаарлагдаад байсан хэрэглэгчдийг төлөвлөсөн хугацаанаас өмнө цахилгаан эрчим хүчинд холболоо.



ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ БАЛАНС

Нийт алдагдлын 40 хувийг 220 кВ-ын шугам сүлжээ, 55 хувийг 110, 35кВ-ын шугам сүлжээ дээр алдсан байна.



Компанийн хэмжээнд 2023 онд 7,488.3 сая.кВт.цаг цахилгаан эрчим хүч /ЦЭХ/ хүлээн авах төлөвлөгөөтэй байснаас гүйцэтгэлээр 7,777.4 сая.кВт.цаг цахилгаан эрчим хүч хүлээн авч, биелэлт 103.9%-тай байна. Компани 7,220.5 сая.кВт.цаг ЦЭХ дамжуулах төлөвлөгөөтэй байснаас 7,501.2 сая.кВт.цаг ЦЭХ дамжуулж, биелэлт 103.9%-ийн гүйцэтгэлтэй гарсан нь

- 2023 оны хувьд жилийн таван сар нь ЦЭХ-ний хөнгөлөлттэй байсан. Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор нийслэл болон аймгийн төв, арван мянгаас дээш хүн амтай сум, суурин газрын гэр хорооллын хоёр тарифт тоолууртай өрхийн орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны тариф болон сэргээгдэх эрчим хүчийг дэмжих тарифт хөнгөлөлт үзүүлэх тухай ЭХЗХ-ны 562-р тогтоолыг хэрэгжүүлэн ажилласан
- Тайлант жилийн 11, 12 дугаар сард цаг агаар хүйтэн байсан
- Уул уурхайн хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний хэрэглээ өссөнтэй холбоотой байна.


Дамжуулалтын нийт алдагдалд 267.8 сая.кВт.цаг буюу 3.58%-ийг зарцуулахаас 276.2 сая. кВт.цаг буюу 3.55%-ийг зарцуулж, алдагдал 0.03%-иар буурсан.



Техникийн алдагдалд 252.7 сая.кВт.цаг буюу дамжуулалтын 3.37%-ийг зарцуулахаас 262.8 сая.кВт.цаг буюу 3.38 %-ийг зарцуулж, өсөлтийн хэмжээ 0.005 хувьтай байна. Дамжуулалт төлөвлөснөөс 3.8 хувь буюу 289.1 сая.кВт.цагаар нэмэгдсэн тул техникийн алдагдал өссөн.

Дотоод хэрэгцээнд 15.1 сая.кВт.цаг буюу 0.20%-ийг зарцуулахаас 13.3 сая.кВт.цаг буюу 0.17% ЦЭХ зарцуулж, зарцуулалт 1.8 сая.кВт.цаг буюу 0.03% буурсан.



2023 ОНЫ НИЙТ АЧААЛАЛ



ХЯЗГААРЛАЛТЫН ТАЛААР


2023 онд нийт 32 удаа 2262.24 МВт буюу 3.3 сая кВт.цаг ЦЭХ-ийг хязгаарласны 85 % нь импортын чадал хэтэрснээс, 9.5 % нь ТЭЦ-4-н хэсэгчилсэн 0 зогсолт, 4% нь ТЭЦ-4-н зуух, машин доголдсоноос шалтгаалсан байна. 12 дугаар сард огцом хүйтэрч, системийн хэрэглээ өссөнөөр импорт 300 МВт-с хэтэрсэн тул хязгаарлалт хийсэн нь нийт хязгаарлалтын 65 хувийг эзэлсэн.





ТАСРАЛТЫН ТАЛААР


2023 онд 811 тасралт гарсны улмаас 3.7 сая кВт.цаг ЦЭХ-ийг дутуу дамжуулсан. Өмнөх онуудтай харьцуулахад тасралтын тоо нэмэгдсэн нь АРОЛ автоматик 12 удаа ажиллаж, 53 тасралт гарсан, мөн гадны байгууллагын тоноглолын тасралт 125 удаа гарсантай холбоотой байсан. ЦДАШ-д гарсан гэмтлүүд нийт тасралтын 17 хувийг, байгалийн хүчин зүйлсээс шалтгаалсан нь тасралтын 16 хувийг эзэлсэн байна.






ТАСЛАЛТЫН ТАЛААР

2023 онд нийт 1956 таслалт хийгдэж, 8.2 сая кВт.цаг ЦЭХ-ийг дутуу дамжуулсан байна. Урсгал засварын болон схем найдваржуулах ажлын шаардлагаар хийсэн таслалт 38 хувийг эзлэж байгаа бол 15 хувийг их засвар болон шинэчлэлийн ажлын үеэр хийсэн. Энэ нь цаашид хэрэглэгчдийн цахилгаан хангамжийг сайжруулж, аль болох олон талаас тэжээгддэг байдлаар шийдвэрлэх шаардлага байгааг харуулж байна.



Таслалтын тоог цөөрүүлэх зорилгоор шугам тоноглолын болон тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн ажлын таслалтуудыг нэгтгэн диспетчерийн болон горимын зохицуулалт хийж, ДҮТ-ийн удирдлага, мэдлийн тоноглолд хамаарах 1072, өөрийн болон бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн удирдлага, мэдлийн тоноглолд 1942, нийт ажлын 3014 захиалгын шуурхай зохицуулалтыг хийж ажилласан.



РЕЛЕ ХАМГААЛАЛТ, АВТОМАТИК, ХЭМЖИЛТ ТҮРШИЛТ

Цахилгаан дамжуулах агаарын шугамын эсэргүүцэл хэмжих ажил

ХБС-н 110 кВ-н 11-н шугам, ГБС-н 110 кВ-н 2, 220 кВ-н 2 шугамын шууд болон тэг дарааллын эсэргүүцлийн хэмжилтийг OMICRON CPC-100 багажаар хийж РХА-н хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажилласан.



OMICRON CPC-100 багажаар хэмжилт хийх явц

ЦДҮС ТӨХК-ийн харьяа 5 салбарын 82 дэд станцын тогтмол гүйдлийн үүсгүүр болон аккумуляторын байгууламжийг 2 үе шаттайгаар шинэчлэх ажлын ТЭЗҮ-г боловсруулсан. 2024 оны II улиралд батлуулан хэлэлцүүлэхээр бэлдэн ажиллаж байна.


Шинэчлэлийн 1-р үе шатны ажлын хүрээнд дараах дэд станцуудын тогтмол гүйдлийн үүсгүүр болон аккумуляторын байгууламжийг шинэчилнэ. Үүнд:

- Улаанбаатар салбарын 14 дэд станц (110/35/10 кВ Налайх, 220/110/35 кВ Улаанбаатар, 110/10 кВ Амгалан, 110/35/10 кВ Дорнод-2, 110/35/10 кВ Туул, 110/10/6 кВ Умард, 110/10 кВ Баруун, 110/10/6 кВ Өмнөд, 110/35/10 кВ Цэвэрлэх, 110/35 кВ ИХБ-3, 220/110 кВ ИХБ-4, 110/35/10 кВ Баянчандмань, 110/35/10 кВ Яармаг, 110/35/10 кВ Дарь-Эх)
- Төвийн бүсийн салбарын 5 дэд станц (110/6 кВ Шарын гол, 110/35/6 кВ Зүүнхараа, 110/35/6 кВ Хөтөл, 110/35/10 кВ Борнуур, 110/35/10 кВ Баруунхараа),
- Зүүн-Өмнөд бүсийн салбарын 3 дэд станц (220/110/35/6 кВ Чойр, 110/35/6 кВ Өндөрхаан, 110/35/6 кВ Бор-Өндөр)
- Хангайн бүсийн салбарын 3 дэд станц (110/10 кВ Тосонцэнгэл, 110/35/6 кВ Баянхонгор, 110/10 кВ Хялганат)
- Говийн бүсийн салбарын 1 дэд станц (110/35/10 кВ Даланзадгад)

Шинэчлэлийн 2-р үе шатны ажлын хүрээнд дараах дэд станцуудын тогтмол гүйдлийн үүсгүүр болон аккумуляторын байгууламжийг шинэчилнэ. Үүнд:

- Улаанбаатар салбарын 13 дэд станц (110/10/10 кВ Гео, 110/10/6 кВ Дундгол, 110/35/10 кВ Багахангай, 110/35/10 кВ Залаат, 110/35/10 кВ Найрамдал, 110/10 кВ Буянт-ухаа, 110/35/10 кВ Телевиз, 110/35/10 кВ 7-р хороолол, 110/35/10кВ Шинэ яармаг, 110/10 кВ Хөшигт, 110/10 кВ Улаанхуаран, 110/10/10 кВ Хүчит шонхор, 110/10 кВ ПРП)
- Төвийн бүсийн салбарын 10 дэд станц (220/110/35 кВ Дархан, ДДЦС ХХБ-110 кВ, 110/35/6 кВ Хөтөл, 110/35/6 кВ Баясгалант, 110/6 кВ Бурхант, 110/6 кВ Давхар, 110/10 кВ Ерөө, 110/35/6 кВ Сүхбаатар, 110/6 кВ Үйлдвэр, 110/35/6 кВ Бугант)
- Зүүн-Өмнөд бүсийн салбарын 11 дэд станц (220/110/35 кВ Багануур, 110/6 кВ Хот, 110/6 кВ Төв, 110/35/10 кВ Сайншанд, 110/10 кВ Замын-үүд, 110/35/10 кВ Айраг, 110/10 кВ Борхой, 110/10 кВ Ширээт, 110/35/6 кВ Өндөрхаан, 110/35/6 кВ Бор-Өндөр, 220/110/35 кВ Чойр)
- Хангайн бүсийн салбарын 10 дэд станц (220/110/35 кВ Эрдэнэт, 110/35/10 кВ Булган, 110/35/10 кВ Сансар, 110/35/10 кВ Хархорин, 110/35/10 кВ Цэцэрлэг, 110/35/10 кВ Арвайхээр, 110/35/10 кВ Баянтээг, 110/35/6 кВ Баянхонгор, 110/35/6 кВ Мөрөн, 110/10 кВ Хялганат)

TORHEL-930 Маркийн тогтмол гүйдлийн үүсгүүрийн ажиллагаа, аккумуляторын байгууламжийн төлөв байдлыг тодорхойлох бүрэн хэмжилт туршилт хийдэг багажтай болсноор компанийн 5 салбарын 50 дэд станцын аккумуляторын байгууламжийг хэмжих, шаардлага хангахгүй шулуутгагч болон элементүүдийг цаг алдалгүй сольж, системийн найдвартай ажиллагаанд үнэтэй хувь нэмэр оруулсан.



Дэд станцын тогтмол гүйдлийн үүсгүүрийн ажиллагаа, аккумуляторын байгууламжийн төлөв байдлыг тодорхойлох түвшинт хийж буй нь

ЦДҮС ТӨХК-ийн Цахилгаан хэмжлийн итгэмжлэгдсэн лаборатори болох

ХБНГУ-ын РТВ төслийн хүрээнд Цахилгаан төслийн хурал семинар, сургалтанд оролцсон. Төслийн хүрээнд манай компанид нийлүүлсэн 0,01% нарийвчлалын өндөр хүчдэлийн эталон багаж тоног төхөөрөмжийн үйлдвэрийн сургалтыг онлайн хэлбэрээр зохион байгуулж, тоног төхөөрөмжүүдийг амжилттай ажиллагаанд оруулсан. Тус тоног төхөөрөмжүүд нь Монгол улсын өндөр хүчдэлийн үндэсний эталон болно.

Лабораторийн итгэмжлэлийн бэлтгэл ажлын хүрээнд нэн шаардлагатай IEC 61869-2:2012, IEC 61869-3:2011, IEC 61869-5:2011 цуврал 3 стандартыг орчуулан Эрчим хүчний үндэсний төв, ЭХЯ-ны ШУТ Хорооны хурал, 2023.12.08-нд СХЗГ-ын стандартын техникийн хорооны хурлаар тус тус хэлэлцүүлэн 1:1 харьцаагаар Монгол улсын үндэсний стандарт болгон батлуулахаар шийдвэрлэсэн. Компанийн лабораторид итгэмжлэл авах бэлтгэл ажлын хүрээнд 21 журам, стандарт ажлын 10 заавар, шалгалт тохируулгын 2 аргачлалыг боловсруулан батлуулж, цахилгаан хэмжлийн лаборатори нь 2024 онд гүйдэл, хүчдэлийн эталон бүхий төхөөрөмжөөрөө Монгол улсын итгэмжлэгдсэн лаборатори болохоор ажиллаж байна.



Цахилгаан хэмжлийн лаборатори



ТЕХНИКИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ

Техникийн үйл ажиллагааны бодлогыг тодорхойлох, төлөвлөх чиглэлээр ажлын хүрээнд өвөл зуны горим ажиллагааг төлөвлөж, хэрэгжилтийг хангуулах, дамжуулах сүлжээний хүндрэлтэй эмзэг цэгүүдэд судалгаа тооцоо хийж, шаардлагатай арга хэмжээг авах, эрчим хүчний салбарын хэмжээнд гаргаж буй төлөвлөлт, бодлогын баримт бичигтэй уялдуулж томоохон эх үүсвэрүүдийн бүтээн байгуулалтын төсөлд хамтран ажиллах, зураг төсөл боловсруулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Компанийн техникийн бодлогын бичиг баримтыг шинэчлэн боловсруулж, 2023-2023 онуудад хэрэгжүүлэх бодлого, хийх ажил, хүрэх түвшинг гаргаж Гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулсан.

Өвөл, зуны горим ажиллагааг боловсруулах, батлуулах, хяналт тавьж ажиллах, дүн шинжилгээ хийх, өргөтгөлөөр буюу шинээр ашиглалтад орж байгаа дэд станц болон ЦДАШ-н зурагт хяналт тавьж ажиллалаа. Компанийн дамжуулах сүлжээний өвөл, зуны горим тооцооллыг болон цаг үеийн горимын тооцооллыг тухай бүр хийж, тулгамдаж буй асуудлаар танилцуулга, материал бэлтгэн асуудлыг дэвшүүлж, шийдвэрлүүлж ажиллалаа.

Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжүүлэх Ухаалаг эрчим хүчний систем төслийн ТЭЗҮ-д дүн шинжилгээ хийсэн Франц улсын RTE international ХХК-ийн тайланд менежментийн зардалтай холбоотой санал өгч ажилласан.

Мандалговь-Арвайхээр, Багануур-Чойр чиглэлийн 220 кВ-ын ЦДАШ, дэд станц болон Парк дэд станцын техник, эдийн засгийн үндэслэлийг бие даан боловсруулж ажилласан.

Компанийн хэмжээнд шийдвэрлэх шаардлагатай, тулгамдсан, цаг үеийн холбогдолтой 45 асуудлаар ҮТЗ-ийн хурлыг хуралдуулж, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж байна.

2023-2024 өвлийг давах бэлтгэл ажлыг шалгах ерөнхий инженерийн нэрэмжит үзлэгийг зохион байгуулж, хууль тогтоомжийн хэрэгжилт, дэд станцын үйл ажиллагаа, ИЗ, УЗ, ТЗБАХ-аархийг дэжбайгаа ажлуудын явц, бичиг баримтын бүрдүүлэлтэд хяналт тавьж, сэрэмжлүүлэх мэдээ даалгаврын хүрээнд шуурхай ажиллагааны ажилтнуудад сургалт явуулсан.

Компанийн хэмжээнд өвөл зуны горим боловсруулах, шинэ эх үүсвэр, хэрэглэгчдийг Төвийн бүсийн эрчим хүчний системтэй холбох зэрэг бүхий л тооцоог Powerfactory программ дээр гүйцэтгэсэн. Томоохон тооцоо, судалгааны ажлуудаас дурдвал:

- Парк дэд станцын ТЭЗҮ-н горимын тооцоо, ачааллын судалгаа
- Мандал-Арвайхээр агаарын шугам, 220 кВ-ын дэд станцын ачааллын судалгаа, таац
- Багануур-Чойрын 220 кВ-ын агаарын шугамын горимын тооцоо, ачааллын таац
- БНХАУ-аас ЦЭХ импортлон авах үеийн схем холболт, горимын тооцоо
- Гацуурт орчмын хэрэглэгчдийн ЦЭХ-ээр хангах боломжийг судлах, Гачуурт дэд станцын схемийн шийдэл, горимын тооцоо
- 110/10 кВ-ын Айлбаян дэд станцыг 220/22 кВ-ын Цагаансуварга дэд станцтай агаарын шугамаар холбох үеийн тооцоо
- 110 кВ-ын Хөтөл-А, Б ЦДАШ-аас салбарлан төмрийн үйлдвэрүүдийн цахилгаан хангамжийг тэжээх боломжийг судлах горимын тооцоо
- 220/110/35 кВ-ын Чойр дэд станцаас холбогдохоор төлөвлөсөн сэргээгдэх эх үүсвэрүүдийн тооцоо
- Орхон аймгийн цахилгаан хангамжийг өргөтгөн 35 кВ-ын тойрог сүлжээг үүсгэн ТБНС-д холбох үеийн горимын тооцоо, санал
- Сэлэнгэ аймгийн 50МВт-ын дулааны цахилгаан станцыг эрчим хүчний нэгдсэн

системд холбох хяналтын горимын тооцоо

- ДЦС-2-ын 0,4/6 кВ-ын шинийн хэрэглэгчдийг шилжүүлэх үеийн горимын тооцоо
- “Чойр-Бор-Өндөр”-ийн 220 кВ-ын 2х125 МВА чадалтай дэд станц, ЦДАШ барих боломжийн горимын тооцоо, ачааллын судалгаа
- 203, 204-р АШ-ыг таслаж, дамжуулагчийн эсэргүүцэл хэмжих ажил гүйцэтгэх үеийн горимын тооцоо
- 35кВ-ын Котель-А, Б ЦДАШ-аас ЦРП-1, ЦРП-5 дэд станцуудын хүчин чадлыг 2*16МВА болгон өргөтгөх, 110кВ-ын ГОК-Г, Д ЦДАШ-аас авсан 110/6/6 кВ-ын Аранжин дэд станцаас 2х4МВт ачаалал өгөх үеийн горимын тооцоо
- 215-р АШ-ыг тасрах үеийн аваарын тооцоо

Зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд ТЗБАХ-ээр хийгдэх 28 ажлын зураг төсөл боловсруулж, ТЗЭ байгууллагуудтай дэд станц, АШ-ын 9 багц зураг төсөлд хамтран ажилласан. Үүнд:

- 220 кВ-ын Багануур-Бөөрөлжүүт АШ, Бөөрөлжүүт цахилгаан станц
- 80 МВт/200 МВт.цаг Батарей хуримтлуурын дэд станц
- Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд Сэлбэ-Сэргэлт авто замын төсөл
- 220/110/35 кВ-ын Оюут дэд станц, 220 кВ ЦДАШ, Эрдэнэт дэд станцын өргөтгөл
- 220 кВ-ын Багануур-Чойр, Багануур-Налайх-Улаанбаатар, Багануур-Чингис-Чойбалсан, Сонгино-Дархан тус бүр 2 хэлхээ ЦДАШ-ын ажлын зураг төсөл
- Налайх, Чингис, Чойбалсан, Сэргэлэн, Ширээт, Парк, Аэросити, Зуунмод дэд станцуудын ажлын зураг төсөл
- Улаанбаатар, Сонгино, Дархан, Чойр, Багануур, Өндөрхаан, Тавантолгой дэд станцуудын өртгөтгөлийн ажлын зураг төсөл

Эрчим хүчний яамны техникийн нөхцөл олгох ажлын хэсгийн хурлаар 175 хүсэлтийг хэлэлцүүлж, компанийн эзэмшлийн дэд станцаас нийт 115 техникийн нөхцөл олгогдож, компанийн техникийн нөхцөл олгох комисс 17 техникийн нөхцөлийг шийдвэрлэсэн. Үүнд:

- Цахилгаан эрчим хүчээр хангах, түгээх зөвшөөрөл бүхий улс болон хувийн хэвшлийн компаниудын хэт ачаалагдсан 10 кВ-ын фидерүүдийн ачаалал хөнгөлөх
- Улаанбаатар хотод шинээр төлөвлөгдөж байгаа авто замтай холбоотойгоор 110 кВ-ын ЦДАШ-ын тулгуур өндөрлөх, шилжүүлж зөөх.



Компанийн 69 дэд станцын барилга байгууламжид хийсэн үзлэг шалгалтаар хийц бүтээцэд үүссэн эвдрэл гэмтэл болон найдваржилтад эрсдэлийн үнэлгээ хийсэн.

Эрчим хүчний болон бусад мэргэжлийн байгууллагуудаас боловсруулсан 19 нэр төрлийн норм, стандарт, 1 нэр төрлийн технологийн карт, шинэчлэн боловсруулагдаж байгаа 4 нэр төрлийн норм дүрмийн төслийг судалж, саналаа хүргүүлэн эрчим хүчний салбарт шинэчилсэн, нэмэлт өөрчлөлт орсон болон шинээр батлагдсан MNS стандарт, норм норматив, дүрэмийн 54 нэр төрлийн бичиг баримтуудыг “Техникийн мэдээллийн нэгдсэн сан” дахь мэдээллийн баазад оруулж, баяжилт хийлээ.

Дамжуулах сүлжээнд “Өндөр хүчдэлийн итгэмжлэгдсэн лаборатори” байгуулах ажлын хүрээнд MNS IEC 61869-2:2023 Хэмжүүрийн трансформатор 2-р хэсэг буюу Нөлөөмжийн хүчдэлийн трансформаторын нэмэлт шаардлага, MNS IEC 61869-3:2023 Хэмжүүрийн трансформатор 3-р хэсэг буюу Нөлөөмжийн хүчдэлийн трансформаторт тавих нэмэлт шаардлага, MNS IEC 61869-5:2023 Хэмжүүрийн трансформатор 5-р хэсэг буюу Багтаамжийн хүчдэлийн трансформаторт тавих нэмэлт шаардлага стандартуудыг орчуулан холбогдох техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. Дамжуулах сүлжээний тосны



химийн лабораторийг MNS 17025:2018 стандартын дагуу хэмжлийн чадавхийг үнэлүүлж, магадлан итгэмжлэл хийлгэх ажлын хүрээнд MNS IEC 60156:2023 “Тусгаарлагч шингэн-Эвдрэлийн хүчдэлийг эрчим хүчний системийн давтамжид тодорхойлох-Туршилтын арга”, MNS ASTM D924-15:2023 “Цахилгаан тусгаарлагч шингэний алдагдлын чадлын коэффициент, харьцангуй хөндийрүүлгийн диэлектрикийг турших арга” олон улсын стандартын орчуулгын төслийг салбарын болон холбогдох байгууллагуудаас шүүмж, санал авч байна.



Өвлийн хяналт хэмжилтийг
2022.12.21-ны өдрийн
04:00, 11:00, 19:00, 23:00
цагуудад зохион
байгуулсан.

Зуны хяналт хэмжилтийг
2023.06.21-ний өдрийн
04:00, 12:00, 15:00, 18:00
цагуудад зохион
байгуулсан.

2023.12.20-нд өвлийн их
ачааллын хэмжилтийг зохион
байгуулахаар бэлтгэл ажлыг
ханган ажиллаж байна.



ЗАСВАР ЗОХИЦУУЛАЛТ

2023 онд их засварын 293 ажлыг 3.6 тэрбум.төг, техник зохион байгуулалтын арга хэмжээний 85 ажлыг 9.3 тэрбум.төг, хөрөнгө оруулалтын 43 ажлыг 1.0 тэрбум төгрөг буюу нийт 421 нэр төрлийн ажлыг 13.9 тэрбум төгрөгөөр хийхээр төлөвлөснөөс ИЗА-аар 292, ТЗБАХ-ээр 82, ХО-аар 43 буюу нийт 417 ажлыг 9.9 тэрбум төгрөгөөр 99 хувьтай гүйцэтгэсэн.

Хийгдсэн томоохон ажлууд:

- Их засварын ажлаар Буянт-Ухаа Т-2 трансформаторын гэмтэл устгах, Чойр дэд станцаас буулгасан 63 МВА автотрансформаторын засвар, АШ-203, 204, 207, 208, 215, 216, 225 цахилгаан дамжуулах агаарын шугамуудын засвар үйлчилгээний ажлуудыг гүйцэтгэсэн.
- ТЗБАХ-ний ажлаар Эрдэнэт дэд станцын 220 кВ-ын хуурай салгуур шинэчлэх, Багануур 220 кВ-ын ИХБ-ийн өргөтгөл, шинэчлэлтийн ажил, Дорнод-2 АУРА, Мандал дэд станцын АУРА, 35 кВ талд ДЗШ, Ачаалал хөнгөлөх автоматжуулалтын системийн сүлжээ үүсгэх зэрэг томоохон ажлуудыг гүйцэтгэсэн.
- Хөрөнгө оруулалтын ажлаар тоноглолын диагностик оношилгооны багаж, автокранд зориулалтын сагс, машин механизм зэргээр төлөвлөн гүйцэтгээд байна.

Трансформаторын засварын цехэд 63 МВА, 40 МВА хүчин чадалтай хүчний 2 трансформаторт бүрэн задаргаат их засварын ажил, 7 трансформаторт хөндийрүүлэг сайжруулах хатаалтын ажил, 2 трансформаторыг зөөж шилжүүлэх, угсарч суурилуулах, задлах оношлох, тос эргүүлэх зэрэг ажлуудыг гүйцэтгэснээр нийт 11 ширхэг трансформаторт их болон бага хэмжээний засвар, үйлчилгээ үзүүлэн ажилласан байна.



Хүчний трансформаторын бүрэн задаргаат их засварын ажил

Тосны химийн лаборатори нь тосны сорил шинжилгээний 8 нэр төрлийн багажаар 6 төрлийн шинжилгээг иж бүрнээр гүйцэтгэж байгаа бөгөөд 2023 онд 80 удаа хийн хроматографийн, 100 удаа усны агууламжийн, 70 удаа цахилгаан даацын шинжилгээ хийж, хатуу тусгаарлагчийн чийгийг 5 удаа тодорхойлон дүгнэлт гарган ажилласан. Мөн тосны химийн лабораторийг олон улсын шаардлагад нийцсэн итгэмжлэгдсэн лаборатори болгох зорилтыг хэрэгжүүлэн 80 орчим хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна.




Тосны химийн лаборатори

Клин Энержи ХХК-тай байгуулсан гэрээт ажлын хүрээнд Салхит салхин цахилгаан станцын цахилгаан тоног төхөөрөмжид үзлэг, засвар үйлчилгээг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж найдвартай ажиллагаа болон бэлэн байдлыг жилийн турш ханган ажиллаа.



Тосны химийн лаборатори

Компани Бөөрөлжүүтийн цахилгаан станцыг Төвийн эрчим хүчний системтэй холбох Багануур-Бөөрөлжүүт чиглэлийн 71,72 км урт бүхий 220 кВ-ын 261, 262 дугаар АШ-ын барилга угсралтын ажлын 1 дүгээр багц буюу тулгуур №1-51-ийн хоорондох барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр шалгарч, 15 орчим техник хэрэгсэл, 100 гаруй ажилтны бүрэлдэхүүнтэй 2023 оны 5 дугаар сарын 08-ны өдрөөс 10 дугаар сарын 21-ний өдрийн хооронд ажлыг хийж гүйцэтгэсэн. 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр техникийн комиссын шийдвэрээр Багануур-Бөөрөлжүүт 220 кВ-ын ЦДАШ-ын №1-33-р тулгуурыг 209, 210-р агаарын шугамын №279-р тулгуурт шилжүүлэн холбож, хүчдэлд амжилттай залгасан. Тус шугамын барилга угсралтын ажлаар салбар бүрээс засварын ажилчид оролцож, хамтран ажилласнаар харилцан бие биенээсээ суралцах, туршлага хуримтлуулах, шинэ залуусыг дадлагажуулж, үр чадварыг нэмэгдүүлэхэд тодорхой хэмжээний ач холбогдол өгсөн.



Багануур – Бөөрөлжүүт чиглэлийн ЦДАШ-ын трасс



Багануур – Бөөрөлжүүт чиглэлийн ЦДАШ-ын бүтээн байгуулалт



ХАМТЫН АЖИЛЛАГАА, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

1. ТӨВИЙН БҮСИЙН ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ, ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНИЙ ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТӨСӨЛ

Төслийн хүрээнд Улаанбаатар хот, 10 аймгийн нутаг дэвсгэрт орших цахилгаан дамжуулах сүлжээний 220, 110 кВ-ын 32 дэд станцын анхдагч хэлхээний 9 нэр төрлийн нийт 844 тоноглол, хоёрдогч хэлхээний 8 нэр төрлийн 320 реле хамгаалалт, автоматикийн байгууламжийг тус тус шинэчлэх, шинээр 220 кВ-ын 4 дэд станцад алсын хяналт, удирдлагын систем нэвтрүүлэх ажил хийгдэнэ. ЭХЯ-д байгуулагдсан Тендерийн үнэлгээний хороо, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)-ын Сэргээн босголт, зээлийн банк (KfW), төслийн хэрэгжилтийн Зөвлөх ХБНГУ-ын Integration Umwelt&Energie компанитай хамтран KfW банкны Худалдан авах ажиллагааны удирдамжийг баримтлан дэд станцуудын шинэчлэлийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах түлхүүр гардуулах нөхцөлтэй олон улсын нээлттэй тендерийг 2023.02.06-ны өдөр ХБНГУ болон МУ-д нэгэн зэрэг зарласан. Тендерт оролцогчид тендерийн техникийн шаардлагыг хангаагүй тул KfW банкны худалдан авах ажиллагааны журамд заасны дагуу тендер шалгаруулалтыг дахин явуулахаар ТҮХ болон KfW банк шийдвэрлэсэн. Тендерийг 2023.08.21-ний өдөр ХБНГУ болон МУ-д нэгэн зэрэг дахин зарласан. Тендерт оролцогчдын техникийн саналыг үнэлэх ажлыг 2023 онд багтаан хийж гүйцэтгэсэн. Тендер шалгаруулалтыг зохион байгуулж дуусгах, шалгарсан компанитай “Ажил гүйцэтгүүлэх гэрээ” байгуулах, шинэчлэлийн ажлын зураг төслийг боловсруулах, батлуулах, тоноглолуудыг үйлдвэрлүүлэх ажлыг 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

2. ПОЛИХЛОРТ БИФЕНИЛ-Г БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ АРГААР УСТГАХ МЕНЕЖМЕНТИЙН ЧАДАВХЫГ БИЙ БОЛГОХ ТӨСӨЛ

Монгол Улсад ашиглаж байгаа эрчим хүчний тостой тоног төхөөрөмжид агуулагдах полихлорт бифенил (ПХБ) хортой бодисыг устгах ажлын хүрээнд 2023 онд нийт 157,186 кг трансформаторын тосыг цэвэрлэн хоргүйжүүлж, физик болон химийн шинж чанарын үзүүлэлтүүдийг зөвшөөрөх хэмжээнд хүргэж ажилласан. Нийт жингээрээ 330,398 кг тостой тоноглолын хатаалт буюу хөндийрүүлэг дээшлүүлэх ажлыг гүйцэтгэж, түүнээс ялган авсан 8,000 кг бүхий ПХБ-ийн хортой хог хаягдлыг мэргэжлийн байгууллагаар байгаль орчинд ээлтэй аргаар устгуулсан.

3. ЭРЧИМ ХҮЧНИЙ СҮЛЖЭЭНД АШИГЛАХ ТОМ ЧАДЛЫН ХУРИМТЛУУРЫН ТӨСӨЛ

Сонгины “Батерей хуримтлуурын станц”-ыг Эрчим хүчний нэгдсэн системд залгаж зүгшрүүлэлт хийсэн. Монгол улсын анхны “220/22/35 кВ-ын 80 МВт-ын том чадлын “Батерей хуримтлуурын станцыг ашиглалтад оруулах ажлын хүрээнд 220/110/35 кВ-ын Сонгино дэд станцад 110 кВ-ын шинээр суурилуулсан бүх тоноглол, “Сонгино БХС”-ын үндсэн 2, дотоод хэрэгцээний 4, инверторын 32 трансформатор, 110/35/0.69/0.4 кВ-н бүх тоноглолыг хүчдэлд залгаж, ачаалал авахуулах нийт 2042 үйлдэл бүхий сэлгэн залгалтын программыг боловсруулж, сэлгэн залгалтын үйлдлийг гардан гүйцэтгэж, ажиллагаанд амжилттай залгалаа. Уг батерей хуримтлуурыг ажиллагаанд залгаснаар өвлийн оргил ачааллын цагуудад оргил ачааллыг хааж оролцох шилжүүлэх, импортын эрчим хүчний хэмжээ буурах боломжтой болсон.

4. ЧОЙР-САЙНШАНДЫН 220 КВ-ЫН ЦДАШ, ДЭД СТАНЦ БАРИХ, САЙНШАНД 220 КВ-ЫН ДЭД СТАНЦ БАРИХ ТӨСӨЛ

2022 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 152/2022 тоот магадлалын ерөнхий дүгнэлт гарч, 2022 оны 12 сарын 14-ний өдөр Сангийн яам болон ЕСБХБ хооронд тусгайлсан зээлийн гэрээ байгуулагдсан. Мөн 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Сангийн яам, ЦДҮС ТӨХК хооронд дамжуулан зээлдэх гэрээ байгуулагдаж төслийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх зөвлөхийг сонгон шалгаруулах олон улсын тендер нь өрсөлдөөнт, нэг үе шаттай (Competitive, single stage)-аар зохион байгуулж, шалгарсан компанитай ЕСБХБ-ны худалдан ажиллагааны журмын дагуу 2024.03.04-ний өдөр 2 тал гэрээнд гарын үсэг зурсан бөгөөд төслийн үндсэн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах талаар Тендерийн Үнэлгээний хороо болон ЕСБХБанк-ны хэлцэл дуусаж, урьдчилсан шалгаруулалттай нэг шатлалт тендер зарлахаар болсон. ТҮХ –ны шийдвэрийн дагуу тендерийн материалыг бэлтгэж дуусаад Банкны “Үл татгалзал” хүлээж байна.





2023 ОНЫ ШИЛДЭГ 10 АЖИЛ

1. Сонгины “Батарей хуримтлуурын станц”-ыг эрчим хүчний нэгдсэн системд залгаж зүгшрүүлэлт хийсэн. Монгол улсын анхны “220/22/35 кВ-ын 80 МВт-ын том чадлын “Батарей хуримтлуурын станцыг ашиглалтад оруулах ажлын хүрээнд 220/110/35 кВ-ын Сонгино дэд станцад 110 кВ-ын шинээр суурилуулсан бүх тоноглол, “Сонгино БХС”-ын үндсэн 2, дотоод хэрэгцээний 4, инверторын 32 трансформатор, 110/35/0.69/0.4 кВ-н бүх тоноглолыг хүчдэлд залгаж, ачаалал авахуулах нийт 2042 үйлдэл бүхий сэлгэн залгалтын программыг боловсруулж, сэлгэн залгалтын үйлдлийг гардан гүйцэтгэж, амжилттай ажиллагаанд залгалаа. Үг батарей хуримтлуурыг ажиллагаанд залгаснаар өвлийн оргил ачааллын цагуудад оргил ачааллыг хааж оролцох шилжүүлэх, импортын эрчим хүчний хэмжээ буурах боломжтой болсон.




“220/22/35 кВ-ын 80 МВт-ын том чадлын “Батарей хуримтлуурын станц

2. Хяналт, удирдлагын мэдээллийн SCADA системд Улаабаатар салбарын шилэн кабельд холбогдсон 28 дэд станцыг хамарсан сүлжээ үүсгэсэн. POWER SCADA системд Төвийн бүсийн салбарын 110/6 кВ-ын Давхар, Бурхант, Үйлдвэр дэд станцуудын РХА-ийн төлөв байдлыг оруулан алсаас удирдах боломжтой боллоо.



УБС-ын 28 дэд станцад сүлжээ үүсгэсэн байдал



ТБС-ын Алсын удирдлагаар таслах залгах үйлдлийг хянах дэлгэц

3. Багануур дэд станцын 220 кВ-ын ИХБ-ийн өргөтгөл, РХА-ийн шинэчлэлт, 220 кВ-ын Бөөрөлжүүтийн цахилгаан станцын 220 кВ-ын ЦДАШ-ын барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэв.




220/110/35 кВ-ын Багануур дэд станцын өргөтгөл



220 кВ-ын Бөөрөлжүүт ЦДАШ-ын барилга угсралтын ажлын явц




4. Монгол Улсын Оюутолгой төсөлд зориулж Өвөр Монголын Эрчим хүчний Олон Улсын Хамтын ажиллагааны компанитай “Цахилгаан эрчим хүч худалдан авах, худалдах тухай гэрээ”-ний хүчин төгөлдөр үйлчлэх хугацааг сунгаж, “Нэмэлт гэрээ”-г 2023.05.12-ны өдөр байгуулсан нь хамтын ажиллагааг эрчимжүүлэх, компанийн эдийн засагт томоохон хувь нэмэр оруулж байгаа онцгой чухал алхам боллоо.



Гэрээ байгуулах үйл явц.

5. 110 кВ-ын Ерөө-Бугант ЦДАШ-ын тасралтын судалгаа, тооцоонд үндэслэн ОХУ-ын “Полимер аппарат” компанийн үйлдвэрлэсэн хэт хүчдэл хязгаарлагчийг нийт 35 тулгуурт суурилуулсан. Хэт хүчдэл хязгаарлагчийг суурилуулсанаар аянгын улиралд агаарын шугамын тасралт багасах боломжтой.



ЦДАШ-д цэнэг шавхагч суурилуулсан байдал


6. Байгалийн гамшигт үзэгдэл, огцом хүйтрэлт, хүчтэй салхи, аадар борооны нөлөөллөөс 220 кВ-ын 203, 204 дүгээр ЦДАШ-ын тулгуур № 68, 220 кВ-ын 215, 216-р шугамын тулгуур №32, 110 кВ-ын Хархорин-А,Б ЦДАШ-ын №463-аас 486-р тулгуурууд мөн №679-өөс 683-р тулгуурууд хугарсан аваарыг богино хугацаанд арилгаж, хурдан шуурхай гэмтлийг засварлаж найдвартай ажиллагааг хангасан.



220 кВ-ын 203, 204-р шугамын тулгуур №68-д гэмтэл устгах, сэргээн босгох ажил



220 кВ-ын 215, 216-р шугамын тулгуур №32-д гэмтэл устгах, сэргээн босгох ажил




110 кВ-ын Хархорин-А, Б АШ-д гэмтэл устгах, сэргээн босгох ажил



7. 220/110/35 кВ-ын Чойр дэд станцаас буусан автотрансформаторт бүрэн задаргаат их засварын ажил, 110/10 кВ-ын Буянт-Ухаа дэд станцын Т-2 трансформаторын гэмтлийг засварласан. Эрдэнэт дэд станцад 63 МВа-ийн Т-1, Т-2 трансформатор, Баянхонгор дэд станцад 16 МВа-ийн Т-1 трансформатор, Мөрөн дэд станцад 6,3 МВа-ийн Т-3 трансформатор, Хархорин дэд станцад 15 МВАр-ын Баянхонгор дэд станцад 5 МВАр-ын СВГ суурилуулсан.



Суурилуулсан трансформатор



Хархорин дэд станцын СВГ төхөөрөмж



Трансформаторын засварын ажил

8. Ажилтны үндсэн цалинг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дунджаар 68.5 хувиар нэмэгдүүлсэн.
9. “Инженер техникийн ажилтнуудын зөвлөгөөн -2023”-ыг зохион байгуулав. 220 кВ-ын Мандалговь-Арвайхээр, Багануур-Чойр цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, 110/10 кВ-ын Парк дэд станцын техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлыг гүйцэтгэв.




“Инженер техникийн ажилтнуудын зөвлөгөөн -2023”-д оролцсон инженер техникийн ажилтнууд



Гүйцэтгэсэн Техник эдийн засгийн үзүүлэлт



10. TORKLE – 930 маркийн багажаар 50 дэд станцын аккумуляторын байгууламжид хэмжилт хийж шаардлага хангахгүй болсон шулуутгагч болон аккумуляторын батареийг тодорхойлсон. OMICRON CPC-100 маркийн багажаар 220, 110 кВ –ын ЦДАШ-ын бодит эсэргүүцлийг хэмжиж микропроцессорын реле хамгаалалт болон аваарын бичигч төхөөрөмжид шугамын параметрийн бодит утгыг оруулсан.



OMICRON CPC-100 маркийн ЦДАШ-ын бодит эсэргүүцлийг хэмжих багажаар
хэмжилт хийж байна

2023 ОНЫ ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ

№	Зорилт	Биелэлт
1	2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ БИЕЛҮҮЛЭХ (18 АРГА ХЭМЖЭЭ)	98%
2	ДАМЖУУЛАХ СҮЛЖЭЭНИЙ НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ХАНГАХ (42 АРГА ХЭМЖЭЭ)	98%
3	ДАМЖУУЛАХ СҮЛЖЭЭНИЙ ХҮЧИН ЧАДАЛ ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ, ЗУРАГ ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ (11 АРГА ХЭМЖЭЭ)	95%
4	ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ, ТӨСЛИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ (8 АРГА ХЭМЖЭЭ)	88%
5	КОМПАНИЙН ХЭМЖЭЭНИЙ ТАСРАЛТЫГ БУУРУУЛАХ (18 АРГА ХЭМЖЭЭ)	99%
6	ОСОЛ АВААРГҮЙ АЖИЛЛАХ (15 АРГА ХЭМЖЭЭ)	100%
7	АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ (10 АРГА ХЭМЖЭЭ)	100%
8	УХААЛАГ СҮЛЖЭЭ ҮҮСГЭХ (16 АРГА ХЭМЖЭЭ)	99%
9	ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ, ХЭМНЭЛТИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ (9 АРГА ХЭМЖЭЭ)	90%
10	КОМПАНИЙН ҮНЭТ ЗҮЙЛ-ЭРҮҮЛ АЖИЛТАН-БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ (21 АРГА ХЭМЖЭЭ)	98%
БИЕЛЭЛТ /169АРГА ХЭМЖЭЭ/		97.5%



2024 ОНЫ ЗОРИЛТ

1. 2024 оны үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг биелүүлэх
2. Дамжуулах сүлжээний найдвартай ажиллагааг хангах
3. Үйл ажиллагааны бүх чиглэлээр судалгаа шинжилгээний ажлыг тогтмолжуулах, инновацын шинэ техник технологийг үе шаттай нэвтрүүлэх
4. Компанийн хэмжээний насжилт өндөртэй тоноглолуудын найдвартай ажиллагааг хангах, судалгаа хийх тасралтыг бууруулах
5. Осол авааргүй ажиллах
6. Авлигатай тэмцэх, хууль эрх зүйн орчныг сайжруулах
7. Ухаалаг сүлжээ үүсгэх
8. Эрчим хүчний зохистой хэрэглээ, хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлж ажиллах
9. Компанийн үнэт зүйл-эрүүл ажилтан-байгальд ээлтэй үйл ажиллагаа явуулах
10. Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, төслийн үр ашгийг дээшлүүлэх

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК

Утас	(976) 7004-2939
Факс	(976) 7004-3287
Электрон шуудан	info@transco.mn
Хаяг	Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө - 45, Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ ТӨХК-ийн төв байр
Цахим хуудас	https://transco.mn

УЛААНБААТАР САЛБАР

Утас	(976) 7004-1111, (976) 7004-5008
Факс	(976) 7004-1111, (976) 7044-1655
Электрон шуудан	info.ubs@transco.mn
Хаяг	Улаанбаатар, Баянгол дүүрэг, 20-р хороо, Эрчим хүчний гудамж

ТӨВИЙН БҮСИЙН САЛБАР

Утас	(976) 7037-3852
Факс	(976) 7037-3225
Электрон шуудан	info.tbs@transco.mn
Хаяг	Дархан-Уул аймаг, Дархан сум, Үйлдвэрийн район

ХАНГАЙН БҮСИЙН САЛБАР

Утас	(976) 7039-6054
Факс	(976) 7039-6054
Электрон шуудан	info.hbs@transco.mn
Хаяг	Орхон аймаг, Баян-Өндөр сум, Баянцагаан баг, Үйлдвэрийн-6

ЗҮҮН-ӨМНӨД БҮСИЙН САЛБАР

Утас	(976) 4021-3034
Факс	(976) 4021-3034
Электрон шуудан	info.zbs@transco.mn
Хаяг	Улаанбаатар, Багануур дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн район

ГОВИЙН БҮСИЙН САЛБАР

Утас	(976) 80020822
Электрон шуудан	info.gbs@transco.mn
Хаяг	Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7-р баг

